

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

**ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ 2012
ОНЫ БИЕЛЭЛТИЙН**

ТАЙЛАН

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2012 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ**

ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2012 ОН

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ 2012 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ – I. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тус төвийн Биет соёлын өвийг хамгаалах хэлтэс нь 2012 онд “Музейн сан хөмрөгийн улсын тооллогын програм хангамжийг боловсруулах”, “Төв аймгийн хойд талын сумдын нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалын бүртгэл, тооллого судалгаа хийх”, “Булган, Дундговь, Орхон, Говьсүмбэр аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэрэл зургийн цомог хэвлүүлэх, Соёлын өвийн мэдээ, мэдээлэл сэтгүүл”, “Бурхан халдун уулын дурсгалт газрын бүртгэл-судалгаа”, “Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын соёлын өвийн бүртгэл, судалгаа” зэрэг 5 анги ажлуудыг хийхээр төлөвлөсөн.

Энэ 2012 онд хөдлөх дурсгалын хувьд музейн сан хөмрөгийн улсын тооллого явагдахтай холбогдуулан музейн ерөнхий бүртгэлийн дэвтрийг програм хангамжид шилжүүлэх, улсын тооллогод зарцуулагдах төсөв, удирдамж боловсруулах, тооллогын сургалтыг зохион байгуулахад голлон анхаарч ажиллалаа.

Үл хөдлөх дурсгалуудыг бүртгэх, тоолох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлуудыг бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсаны дагуу хийлээ.

Соёлын өвийг судлах, сурталчиганы ажилд холдбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээллийн технологийг ашиглах, интернет веб сайтаар дамжуулан олон нийтэд сурталчилж байна. Соёлын өвийг бүртгэл, баримтжуулалтад 3D шинэ технологи нэвтрүүлэх, ашиглах ажлуудыг хийж эхлээд байна.

ТУСГАЙ ЗАХИАЛГАТ БҮТЭЭГДЭХҮҮН

Архангай аймгийн үйл хөдлөх дурсгалыг бүртгэн тоолох ажил -Тус аймгийн 12 сумын нутагт ажилласан тухай



Судалгааны баг Архангай аймгийн Чулуут сум. “100 салаа мод” Баруун гар талаас Г.Анхсанаа, Б.Эрдэнэчимэг, Б.Даваацэрэн, н.Баярсайхан, П.Чинбат нар. 2012.06.19

Соёлын өвийн төвийн мэргэжилтэн, судлаачид урьдчилан төлөвлөсний дагуу 2012 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 28-ныг хүртэлх хугацаанд Архангай аймгийн хойд хэсгийн 7 сумын нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлыг хийсэн бол 9 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаатай өмнөд хэсгийн 12 суманд бүртгэл судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Хээрийн шинжилгээний ажлын бүрэлдэхүүнд Соёлын өвийн төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн, Соёлын өвийн хяналтын улсын /гэрээт/ байцаагч

Б.Даваацэрэн, мэргэжилтэн Г.Анхсанаа, мэргэжилтэн П.Чинбат, жолооч Б.Эрдэнэчимэг нар ажилласан. Мөн урьдчилж тохирсны дагуу тус аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан н.Баярсайхан хамт ажилласан болно.

Бид Өлзийт, Батцэнгэл, Ихтамир, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Чулуут, Булган, Цэнхэр, Төвшрүүлэх, Хотонт, Хашаат, Өгийнуур сум гэсэн дарааллын дагуу ажиллав. Судалгааны баг нэр дурдсан сумдын нутагт нийт 5400 орчим км аялж нийт 260 орчим дурсгалт газрыг улсын бүртгэлд бүртгэн авч тэдгээрийг 180 орчим минутын дүрс бичлэг, 330 орчим кадр хальсны зураг, 12000 гаруй дижитал гэрэл зургаар баримтжуулсан байна.

Мөн хөдөө орон нутгийн холбогдох хүмүүсийг судалгааны ажилдаа татан оролцуулж газар дээр нь мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч бүртгэлийн ажлын арга зүйгээр хангаж ажиллалаа.

Бүтээгдэхүүний анги – I. соёлын биет өвийг хамгаалах үйлчилгээ

1.1 Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллого-Музейн үзмэрийн тооллогын програм хангамж

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод зориулсан "Ерөнхий бүртгэлийн програм"-ын хэрэглэгчийн шаардлагыг боловсруулан бэлэн болгож гүйцэтгэгч мэдээллийн технологийн "Сайбер-Андромеда" ХХК-д хүлээлгэн өгөв. Уг ажлын хүрээнд 2012.01.30-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 9 музейн эрдэм шинжилгээний ажилтан, бүртгэл мэдээллийн санч болон сан хөмрөгч зэрэг 23 ажилтныг хамруулсан 1 цагийн хэлэлцүүлэг хийж, саналуудыг нэгтгэн боловсруулав.

"Сайбер-Андромеда" ХХК-тай хамтран "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл"-ийн "Register" програмыг 2012 оны 7-р сард зохион дуусгаж, улсын тооллогын сургалтын үеэр музейнүүдийн компьютер суурилуулан тараав.

Програмд тооллогын ерөнхий бүртгэлээ оруулж буй явцад музейнүүдээс ирүүлсэн саналын дагуу шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж байна.

Тухайлбал: "Register" бүртгэлийн програмын гэрэл зурагтай ажиллах хэсгийг талбарын багтаамжийг сайжруулсан. Энэ удаагийн улсын тооллогоор аймгийн музей сумдынхаа орон нутаг судлах танхимын тооллогын бүртгэлийг уг програмд шивж оруулах ажлыг хариуцан хийж байгаатай холбогдуулан, аймгийн музейн бүртгэлийн програмд орон нутгийн судлах танхим ажиллаж байгаа сум тус бүрээр талбар хуудас нэмж оруулах ажлыг хийж байна.

Музейн сан хөмрөгийн улсын тооллогын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хийгдсэн ажлуудаас:

- Музейн сан хөмрөгийн 2012-2013 оны улсын тооллого явуулах удирдамж болон улсын тооллогын төсвийн төслүүдийг боловсруулан БСШУЯам, Соёл урлагийн хороонд хүлээлгэн өгсөн. Тус хорооноос улсын тооллогыг чанар, үр дүнтэй явуулахад батлагдсан төсвийн дагуу музейнүүдэд тооллогын зардал хувиарлах, шаардлагатай материал хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Улс болон аймгийн музейнүүдээс БСШУ-ны сайдын 2011 оны 11-р сарын 15-ны өдрийн 1а/6506 тоот "Улсын тооллогын бэлтгэлийг хангах тухай" албан бичигт заагдсан ажлуудын гүйцэтгэлийн талаарх дүн, мэдээг тус хэлтэс дээр хүлээн авч, музейнүүдийн хийгдсэн ажлуудад дүн шинжилгээ хийв.

Музейгээс ирүүлсэн дүн мэдээнээс харахад үзмэрийн хувийн дугаар давхардсан, үзмэр хувийн дугааргүй байх, музейн ерөнхий бүртгэлд огт тусгагдаагүй байх зэрэг

зөрчлүүд багагүй байна. Улсын тооллогын өмнө бүртгэлтэй холбоотой зөрчлүүдээ илрүүлэх, бүртгэл дэх алдаа мадагтай бичлэг, тэмдэглэгээг засах цэгцлэх, ерөнхий бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах арга хэмжээнүүдийг авах нь улсын тооллогыг үр дүнтэй явуулахад чухал нөлөөтэй юм.

- Музейн сан хөмрөгийн улсын тооллогоор өмнөх 2007-2008 оны улсын тооллогын үеэр шийдэгдээгүй үлдсэн музейн үзмэрийн үнэ, үнэлгээний асуудлыг шийдвэрлэх үүднээс “Музейн үзмэр, эд зүйлс, түүх, соёлын дурсгалд үнэ тогтоох үлгэрчилсэн журам”-ыг анхны байдлаар боловсруулан, Улс, аймгийн музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах төв комисст хүлээлгэн өгч, 2012 оны 7-р сар болон 12 дугаарсард уг журмыг батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн болно.

Музейн сан хөмрөгийн улсын тооллогын сургалт зохион байгуулсан талаар:

- БСШУ-ны сайдын мөн 2012 оны 74-р тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2-т улс, аймгийн музейн ажилтнуудад тооллогын сургалт зохион байгуулах тухай заасны дагуу уг сургалтыг 2012 оны 8 дугаар сарын 6-наас 9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Сургалтыг Монголын Үндэсний музейн арга зүйн алба, Байгалийн түүхийн музей, Улсын тооллогын төв комисстой хамтран явуулахаар сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

БСШУ-ны сайдын дээрх тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах удирдамж”-д заагдсан улсын тооллогын зорилго, зорилтуудыг хангахад сургалтын хөтөлбөрийн агуулга чиглэгдсэн юм. Монголын Үндэсний музейгээс боловсруулсан музейн үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах заавар, тооллогын үеэр хөтлөх бүртгэлийн маягтууд, үзмэрт хувийг дугаарын тухай, төрийн өмч, соёлын өвийн бүртгэл, хяналт зэрэг сэдвүүд хичээлийн хөтөлбөрт тусгагдсан байна.

Сургалтанд Улсын болон 21 аймгийн музей, Өвөрхангай аймгийн Төвхөн, Шанхын баруун хүрээ хийд, ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Эрдэнэсийн сан, Үндэсний номын сан, Мэргэжлийн хяналтын газар зэрэг нийт 43 байгууллагын 128 ажилтнууд оролцлоо. Тус сургалтанд музейн захирал, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч, бүртгэл-мэдээллийн санч, мэргэжлийн хяналтын байцаагч зэрэг улсын тооллогод голлон ажиллах албан тушаалын хүмүүс хамрагдсан байна. Аймгийн музейгээр дамжуулан сумдын орон нутаг судлах танхимыг мэргэжил, арга зүйгээр хангаж байна.

Соёлын өвийн төв, Монголын үндэсний музей, Олон улсын музейн зөвлөлийн Монголын Үндэсний хороо, Байгалийн түүхийн музей, Төрийн өмчийн хороо, Улсын мэргэжлийн хяналт, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын холбогдох мэргэжилтэнүүд хичээл заалаа. Сургалтаар заасан мэргэжил, арга зүйн хичээлүүдийг гарын авлага болгон хэвлүүлж, сан хөмрөгийн улсын тооллогод хамрагдах улс, аймгийн музей, орон нутаг судлах танхим, сүм хийд, эрдэм шинжилгээний хүрээлэн, номын сан зэрэг газруудад тараагаад байна.

Мөн энэ үеэр Соёлын өвийн УНБМСангаас сан хөмрөгийн улсын тооллогоор хөтлөх “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийг олгохдоо нэгбүрчлэн “засаг захиргааны нэгжийн ангилал, музейн нэр, дэвтрийн дэс дугаар” бүхий утгыг илэрхийлсэн кодоор дугаарлан, улсын болон аймгийн музейнүүд, сумдын орон нутаг судлах танхимуудад тараав./Дэлгэрэнгүй тайланг хавсаргав/

Тооллогын ажлыг мэргэжил, арга зүйгээр хангах талаар:

Улсын тооллого эхэлснээс хойш музейгээс тооллогын явцын талаар ирүүлсэн тайлан, мэдээг нэгтгэн улсын тооллогын төв комисст хүргүүлэх ажлыг хийсэн.

Энэ удаагийн тооллогод томоохон сүм хийдүүд, Эрдэнэсийн сан зэрэг газруудыг шинээр нэмж хамруулж байгаа юм.

Монгол банкны Эрдэнэсийн сан музейн зориулалтын танхим нь олон нийтэд нээлттэй биш, захиалгаар үйлчилдэг байна. Эрдэнэсийн сангийн бүртгэл, тооллогын ажилд Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, хэлтсийн дарга Д.Нарантуяа нар мэргэжил, арга зүйн заавар зөвөлгөө өгсөн, мэргэжилтэн Б.Алтансүх, П.Чинбат нар тус санд хадгалагдаж буй 500 орчим соёлын өвийн дурсгалыг гэрэл зурагжуулах ажлыг хийж гүйцэтгээд байна. Эрдэнэсийн сан нь үйл ажиллагааныхаа онцлогоос шалтгаалан үзмэр, соёлын өвийг бүртгэх, судлах мэргэжлийн хүн байхгүй учир тооллогын бүртгэлийг хөтлөхөд мэргэжил, арга зүй талаас их дутагдалтай байгаа юм.

Төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа 2012 оны 10 дугаар сард 8 хоног Эрдэнэ-зуу музей, Хархорин музей, Хөшөө цайдам музейд явагдаж байгаа улсын тооллогын явцтай танилцан, Шанхын баруун хүрээ хийдэд тооллогыг явуулсан. Мөн 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Төв аймгийн музей дээр ажиллаж, тус тооллогын ажил байдалтай танилцлаа. /Дэлгэрэнгүй тайлангуудыг хавсаргав/

1.2 Төв аймгийн хойд талын сумдын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, тооллого, судалгаа хийх

Соёлын өвийн төв Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний соёлын өвийн мэдээллийн тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”, Монгол улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 299/324/111 тоот хамтарсан тушаалаар баталсан түүх, соёлын үл хөдлөхтэй холбоотой ажлуудыг нэгтгэн зохион байгуулахаар төлөвлөж 2008 оноос эхлүүлээд байгаа билээ. Бид энэ ажлын хүрээнд 2012 оны 5 дугаар сарын 17-ноос 6 дугаар сарын 03-ныг хүртэлх хугацаанд Төв аймгийн баруун хойд хэсгийн Сүмбэр, Жаргалант, Цээл, Заамар, Угтаалцайдам, Борнуур, Баянчандмань гэсэн 7 сумын нутагт ажиллалаа. Судалгааны багийн бүрэлдэхүүнд Соёлын өвийн төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, тус төвийн бүртгэлийн ажилтан



П.Чинбат, Төв аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Н.Мягмар, бүртгэл-мэдээллийн санч Г.Дагмидмаа, СӨТ-ийн жолооч Б.Эрдэнэчимэг нарын бүрэлдэхүүнтэй ажилласан болно.

Судалгааны баг нэр дурдсан 7 сумын нутагт нийт 2276 км аялж нийт 77



Судалгааны баг Төв аймгийн Заамар суманд. Баруун гар талаас П.Чинбат, Н.Мягмар, Б.Эрдэнэчимэг, Г.Дагмидмаа, Б.Даваацэрэн нар. 2012.05.24

дурсгалыг давтан болон шинээр илрүүлэн бүртгэж тэдгээрийг 2140 ширхэг дижитал эх үүсвэрийн гэрэл зураг, 108 ширхэг хальсны эх үүсвэрийн гэрэл зураг 2 гар зураг, 120 минутын дүрс бичлэгээр тус тус баримтжуулсан байна. Дээрх хуримтлуулсан мэдээллийг эмхэлж цэгцэлж улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалахаар ажиллаж байна.

Судалгааны баг байгууллагын удирдлагад танилцуулж зөвлөсний дагуу 5 дугаар сарын 17-ноос 19-ны өдрүүдэд төлөвлөсөн бүс нутагтай хил залгаа Дархан-Уул аймгийн нутагт орших дурсгалыг бүртгэх, зарим дурсгалын засаг захиргааны нэрийг тодруулах ажлуудыг тус тус хийсэн юм. Энэ ажилд тус аймгийн ЗДТГ-ын БОАЖ-ын газрын мэргэжилтэн Д.Амгалан, музейн бүртгэл-мэдээллийн ажилтан Г.Энхбаяр, эрдэм шинжилгээний ажилтан Б.Уранцэцэг нар оролцон ажилласан. Бид Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор, Шарынгол сумдын нутагт нийт 360 гаруй км аялан 3 дурсгалын харьяалах засаг захиргааг тодруулж, 10-аад дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэлээ.



Судалгааны баг Дархан-Уул аймгийн Хонгор суманд. Баруун гар талаас П.Чинбат, Б.Даваацэрэн, Д.Амгалан, Б.Уранцэцэг, Б.Эрдэнэчимэг нар. 2012.05.18

1.3 “Булган, Дундговь, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэрэл зургийн цомог хэвлүүлэх, Соёлын өвийн мэдээ, мэдээлэл сэтгүүл

ССАЖЯ-ны харьяа Соёлын өвийн төв монгол нутагт оршин буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг анхан шатны байдлаар бүртгэн баримтжуулах, тоолох, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд судалгаа хийх ажлыг 2008-2015 онд гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Бид энэ ажлын хүрээнд Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Өвөрхангай, Дундговь, Архангай аймгийн нутагт ажиллаж 2400 орчим дурсгалт газрын дурсгалыг бүртгэн баримтжуулж, холбогдох мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан болон нэр дурдсан аймгуудын бүртгэл-мэдээллийн санд хадгалаад байна.

Соёлын өвийн төв олон нийтэд монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчилах зорилгоор Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээллийг дээрх ажлын үеэр цуглуулсан мэдээллээр баяжуулан гэрэл зургийн цуврал цомог хэвлүүлж байгаа юм. Бид энэ 2012 онд Булган, Говьсүмбэр, Дархан уул, Орхон, Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг багтаасан 7, 8, 9 дэх цомгоо хэвлүүллээ. Булган аймгийн цомог болох 7-р дэвтэрт 152 дурсгалыг, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгуудыг нэгтгэсэн цомог болох 8-р дэвтэрт нийт 52 дурсгал, Дундговь аймгийн цомог болох 9-р дэвтэрт 176 дурсгалыг тус тус багтаасан байна.

Эдгээр цуврал бүтээлүүдийг сум орон нутгийн Соёлын төв, аймгуудын номын сан, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад үнэ төлбөргүй тараан нийтэд сурталчилж байна.

Тус төвөөс эрхлэн “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийг 2008 оноос эхлэн жил тутамд гаргаж байгаа билээ. Уг сэтгүүлд соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын чиглэлээр бодлогын хэрэгжилт, хийгдэж байгаа үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, мэргэжил арга зүйн зөвлөмж мэдээ, мэдээллийг хэвлэн нийтлүүлдэг. Төлөвлөсний дагуу тус сэтгүүлийн эхийг 2012 оны 12 дугаар сард бэлтгэн, хэвлэлтэд шилжүүлсэн байна.

1.4 Бурхан халдун уулын дурсгалт газрын бүртгэл-судалгаа

2012 оны тавдугаар сарын эхээр ЮНЕСКО-ийн байгалийн болон соёлын өвд бүртгүүлэх дурсгалын урьдчилсан жагсаалтын нэгэнд орсон Төв аймгийн Мөнгөн морьт сумын нутагт орших Бурхан халдун уулын дурсгалт газар хэрглэгдэхүүн цуглуулах судалгааны багийн бүрэлдэхүүнд орж ажиллав. Багийн бүрэлдэхүүнд Байгаль очны яамны Тусгай хамгаалалтын газрын захиргаа, Ханхэнтий байгалийн цогцолборт газрын захиргаа, “Байгаль соёлын өвийг амгаалах төв” ТББ, “Тахилгат уулс” ТББ, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн төлөөлөл орлоо.

Баг Хан Хэнтийн ууланд орших Их бага хоригууд, Хаалга мод, Алтан гадас уул, Босго тэнгэрийн даваа, Рашаан хад, Биндэрийн овоо, Гуа дов, Бүрхийн дөрвөлжин гэх мэт газраар гэрэл зураг, дүрс бичлэг авч, холбогдох тодорхойлолт, бүртгэл баримтжуулалт хийж, хамгаалалтын бүсийн газар зүйн уртраг, өргөрөгийг нарийвчлан гаргах, хамгаалалтын бүсийн хил хязгаарыг урьдчилсан байдлаар тогтоох зэргээр ажиллав.

1.5 Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын соёлын өвийн бүртгэл судалгаа

2011 онд Дэл уулын орчимд ажилласан бүртгэл судалгааны баг тус газарт оршин буй хадны зургийн хадгалалт хамгаалалтын орчинд дүн шинжилгээ хийж нэн даруй хамгаалах нь зүйтэй гэж үзсэн билээ. Уг дүгнэлтэд үндэслэн Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, Өлзийт сумын Засаг дарга н.Энхбат, Дундговь аймгийн музейн захирал М.Бямбажав нар хэд хэдэн удаа албан бус уулзалт хийж, утсаар ярилцсаны үр дүнд Дэл уулын соёлын өвийн иж бүрэн судалгааг 2012-2014 онуудад хийж үр дүнг олон нийтэд сурталчилах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон байна. Уг ажлын хүн хүч, цаг хугацаа, төсөв хөрөнгө, хийгдэх ажлыг оновчтой зөв төлөвлөх, судалгааны ажлыг хэрэгжүүлэх арга зүйг газар дээр нь судлах зорилгоор Соёлын өвийн төв 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд судалгааны баг илгээхээр тусгасан юм.

Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр Соёлын өвийн төвийн захирлын 2012 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн а/34 тоот тушаал гарч хээрийн судалгааны багийг томилсон юм. Уг судалгааны багийн ахлагчаар тус төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, гишүүдэд төвийн мэргэжилтэн Г.Анхсанаа, П.Чинбат, жолоочоор Б.Эрдэнэчимэг нарыг томилж хугацаа, зарцуулах

хөрөнгийн хэмжээг баталсан байна.



Судалгааны баг Дундговь аймгийн Өлзийт сумын “3 цагаан хад”-ны орчим. Баруун гар талаас П.Чинбат, Б.Даваацэрэн, Ж.Мөнхцэцэг, н.Раашинхүү, С.Намжилмаа, Б.Эрдэнэчимэг, М.Бямбажав, Г.Анхсанаа нар. 2012.07.22

Энэхүү туршиц судалгааг хийхэд Дундговь аймгийн музейн 4 мэргэжилтэн судлаач хамтран ажилласан болно.

Судалгааны баг 7 дугаар сарын 16-наас 7 дугаар сарын 23-ныг хүртэлх хугацаанд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын орчимд туршиц судалгааны ажлыг амжилттай хийж дуусгалаа.



Дэл уулын Өлзийтийн хуудасны нэгэн хадны зураг.
2012.07.18



Дэл уулын Өлзийтийн хуудасны нэгэн хадны зураг.
2012.07.18

Судалгааны баг Дэл уулын Өлзийтийн хуудас, баруун Билүүний орчимд 5000 орчим га газар явганаар самналт хайгуул хийж 30 орчим цэгт хадны зургийн шинэ дурсгалыг илрүүлэн тэдгээрийн байршилыг GPS-ээр тогтоож, 1500 орчим гэрэл зургаар баримтжуулсан болно. Мөн төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уран сайхны кино, гэрэл зургийн цомог, интэрнэтэд байршуулах 3D технологи бүхий авто понарамм зэргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг хуримтлуулсан байна. Судалгааны баг дурдан буй ажлуудыг төвлөрүүлэн хийх газрыг 3 цэгт зохион байгуулах нь зүйтэй хэмээн үзэж холбогдох мэдээллүүдээр дэлгэрэнгүй тайлан бичиж байна.

Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдаагүй бусад ажлууд:

Музейн үзмэрийн бүртгэлийн RCH програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн тухай:

Түүх, соёлын хөдлөх дурсгалын бүртгэлийн RCH програм хангамжийг бүртгэх ажлын явцад гарч хүндрэл болон илүү боловсронгуй болгох саналуудаар баяжуулан сайжруулах ажлыг "Сайбер-Андромеда" ХХК-тай хамтран 2012 оны гуравдугаар сарын 05-аас тавдугаар сарын 24-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. Уг сайжруулалтын ажилд дараах ажлууд багтсан.

Үүнд:

1. Палеонтологийн олдворын төрөл зүйлийн сонголтыг дэлгэрэнгүй болгосон,
2. Палеонтологийн олдворын холбогдох он, цагийн сонголтыг дэлгэрэнгүй болгосон,
3. Зургийн тайлбарыг динамик болгосон,
4. Дурсгалыг өмчлөгч, эзэмшигчийн эрхзүйн байдлаас хамаарах ангиллын өөрчлөлтийг хийсэн,
5. Музейгээс дамжуулсан бүртгэлийг веб сайтаас харж болохоор зохицуулсан,
6. Зурагтай ажиллах хэсгийг боловсронгуй болгосон
7. Бүртгэлийн тодорхойлолтыг товч байдлаар хэвлэдэг болгов,

8. Эх бүтээл, хуулбар эсэх сонголтыг баазад оруулсан,
9. Хосгүй үнэт зэрэглэлд санал болгох эсэх асуулгыг оруулсан.

УНБМСанд 2012 онд бүртгэгдсэн үзмэрийн бүртгэлийн судалгаа

Энэ 2012 онд музейн сан хөмрөгийн улсын тооллого явагдаж, музейн ажилтнууд тооллогын ажилдаа түлхүү оролцон ажиллаж байгаагаас шалтгаалан музейгээс “RCH” бүртгэлийн програмдаа үзмэрээ бүртгэн оруулах ажил өмнөх жилүүдийг бодвол харьцангуй удаашралтай байна. 2012 онд 5753 дэсийн 17009 ширхэг үзмэр бүртгэгдсэн байна

№	Байгууллагын нэрс	2012 онд бүртгэгдсэн		УНБМСанд нийт бүртгэгдсэн	
		Дэсийн тоо	Тоо ширхэг	Дэсийн тоо	Тоо ширхэг
1	Монголын Үндэсний музей	1098	3078	2547	4707
2	Төрийн түүхийн музей	0	0	645	654
3	Байгалийн түүхийн музей	2	2	1265	1267
4	Богд хааны ордон музей	465	465	4089	4090
5	Дүрслэх урлагийн музей	172	222	2243	2354
6	Чойжин ламын сүм музей	534	5568	1115	6149
7	Монголын театрын музей	603	771	3504	4037
8	Монгол цэргийн музей	81	81	314	314
9	Уран зургийн галерей	7	7	1619	1642
10	Улаанбаатарын музей	0	0	407	611
11	Өвөрхангай аймаг. Хар хорум музей	0	0	143	216
12	Архангай аймаг. Хөшөө цайдам музей	0	0	126	173
13	Үндэсний номын сан	1	493	630	1122
14	ШУА-ийн Археологийн хүрээлэн	50	3	277	2873
15	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	63	65	67	69
16	Архангай аймгийн музей	790	1483	835	1529
17	Баян-Өлгий аймгийн музей	13	13	881	1774
18	Баянхонгор аймгийн музей	12	908	1432	3454
19	Булган аймгийн музей	132	165	1512	2273
20	Говь-Алтай аймгийн музей	155	155	982	1117
21	Говьсүмбэр аймгийн музей	129	129	424	424
22	Дархан-Уул аймгийн музей	0	0	866	866
23	Дорноговь аймгийн музей	92	216	626	1120
24	Данзанравжаагийн музей	0	0	7	7
25	Дорнод аймгийн музей	3	3	1403	3225
26	Дундговь аймгийн музей	323	615	1036	1328
27	Завхан аймгийн музей	233	279	1683	1844
28	Орхон аймгийн музей	206	206	609	610
29	Өвөрхангай аймгийн музей	7	12	523	1002
30	Өвөрхангай аймаг. Эрдэнэзуу музей	202	1301	1200	2359
31	Өмнөговь аймгийн музей	110	162	913	965

32	Сүхбаатар аймгийн музей	0	0	343	343
33	Сэлэнгэ аймгийн музей	156	170	1007	1025
34	Төв аймгийн музей	3	112	1487	1824
35	Увс аймгийн музей	41	92	608	2084
36	Ховд аймгийн музей	0	0	213	213
37	Хөвсгөл аймгийн музей	4	0	1799	3861
38	Хэнтий аймгийн музей	17	184	1263	1686
	Нийт	5753	17009	40645	65211

Хосгүй үнэт дурсгалын талаар:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5-р зүйлд заасны дагуу дурсгалуудыг зэрэглэлд хамруулах тухай дурсгалын танилцуулгыг бэлтгэн БСШУЯаманд хүлээлгэн өгсөн. Яамны дэргэдэх түүх, соёлын дурсгалт зүйлийг зэрэглэх Мэргэжлийн Зөвлөлийн санал болгосны дагуу Монголын Улсын Засгийн газрын шийдвэрээр 2012 онд Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Эрдэнэ зуу музей, Үндэсний номын сан, МУИС-ийн харъяа Улаанбаатар сургууль зэрэг газруудад хадгалагдаж байгаа 78 дурсгал түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан байна.

Одоогийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 748 дурсгал түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан байна.

№	Байгууллагын нэрс	Хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалын тоо ширхэг
1	Богд хааны ордон музей	1
2	Чойжин ламын сүм музей	25
3	Эрдэнэ зуу музей	32
4	Үндэсний номын сан	10
5	МУИС-ийн харъяа Улаанбаатар сургууль	10
	2012 онд нэмж батлагдсан дурсгалын тоо	78

Судалгаа, сурталчилгааны ажлын талаар

- 2012 оны эхний хагас жилд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 303 тоот тушаалаар хийгдэж буй “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог, цахим каталог хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн хянан зассан музейнүүдийн үзмэрийн тодорхойлолтуудыг улсын болон аймгийн музейнүүдэд хүлээлгэн өгсөн.

www.eheritage.mn сайт буюу “Монголын музейн үзмэрүүд” цахим каталог хийгдэж байгаатай холбогдуулан уг сайттай уялдаж ажиллахаар бүртгэл-мэдээллийн сангийн RCH бүртгэлийн програмд шинэчлэл хийгдсэн билээ. Музейгээс “RCH” програмд үзмэрээ бүртгэснээр уг сайтад мэдээллээ шууд оруулах боломжтой юм.

- БСШУЯамны үүрэг даалгавраар 2012 оны 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт орших Амарбаясгалант хийдийн шинээр авчирсан дээврийн ваарыг сэргээн засварлах ажилд хэрэглэж болох эсэх талаарх мэргэжлийн дүгнэлтийг гаргах, тус хийдэд хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх

дурсгалыг үзэж танилцан, улсын бүртгэлд хамруулах тухай талаар заавар зөвлөлгөө өгч, маягт аргачлалаар ханган ажиллалаа.

Мэдээллийн технологийн чиглэлээр хийгдсэн судалгаа, сурталчилгааны ажлууд:

Манай хэлтсийн цахим мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийн идэвх, санаачлагад түшиглэн 2012 онд мэдээллийн технологийг ашиглан соёлын өвийг сурталчилах талаар амжилттай ажиллалаа.

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогод зориулсан ерөнхий бүртгэлийн Register програм, эртний нүүдэлчдийн язгууртны бунхант булшны виртуал тур, түүхэн дурсгалын сэргээн засварлалтын ажлын танилцуулга веб сайт, хадны зургийн виртуал тур бүхий соёлын өвийн судалгааны веб сайт, Чингис хаантай холбоотой зарим түүхэн газруудын панорама виртуал тур, агуйн бичээсний виртуал тур боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэн цаашид улам боловсронгуй болгон хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Эдгээр ажлуудаас цохон онцолбол Шороон бумбагарын бунхант булшны виртуал тур боловсруулж Уран зургийн галерейд зохион байгуулагдсан “Нүүдэлчдийн урлагийн галерей” үзэсгэлэнд дэлгэн тавьж олны хүртээл болгосон нь үзэгчид болоод салбарын судлаачдын сонирхлыг ихээр татсан юм.

Улаан хэрмийн Шороон бумбагар дурсгалын 360° виртуаль тур боловсруулах ажил:

Булган аймгийн Баяннуур сумын нутгаас олдсон Улаан хэрмийн Шороон бумбагар хэмээх эртний нүүдэлчдийн язгууртны бунхант булшийг мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглан бүртгэн баримтжуулах ажлыг хийж ШУА-ын Түүхийн хүрээлэн, “Сайбер-Андромеда” ХХК, “Урансофт” ХХК-тай хамтран хийж гүйцэтгэлээ.

Уг ажлын хүрээнд дурсгалт газар гурван удаагийн томилолтоор ажиллаж нийт 4.28GB хэмжээ бүхий 1730 орчим кадр зургийг паноромад зориулан авсан. Газар дээр нь ажиллан цуглуулсан хэрэглэгдэхүүнийг нэгтгэн боловсруулж "Нүүдэлчдийн урлагийн галерей" үзэсгэлэнд дэлгэж, монголд анх удаа Археологийн малтлагаар илэрсэн байгууламжийг виртуал тур байдлаар баримтжуулж олны хүртээл болголоо.

“Их бурхант” дурсгалын сэргээн засварлалтын ажлын танилцуулга веб сайт

Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших “Их бурхант” дурсгалын танилцуулга болон сэргээн засварлалтын ажлын дэлгэрэнгүй мэдээлэл бүхий www.ikhburkhant.eheritage.mn веб сайтыг ашиглалтад оруулаад байна.

Энэхүү сайтаас Жанрайсиг бурханы сэргээн засварлалтын өмнөх байдал, сэргээн засварлалтын явц болон сэргээн засварлалтын дараах байдлыг 3600 панорама виртуал тур-аар харьцуулан харах боломжтой юм. Соёл, Спорт, Аялал жуулчлалын яам, Соёлын өвийн төв, “Урансофт” ХХК-тай хамтран ажиллав.

Дэл уул орчмын соёлын өвийн судалгааны веб сайт

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уул орчмын соёлын өвийн танилцуулга болон судалгааны ажлын тоймыг нэгтгэсэн www.deluul.eheritage.mn веб сайт нь хийж, ашиглалтад оруулаад байна. Энэхүү сайтаас Баруун билүүний хийдийн туйр болон зарим алдартай хадны зургийг 3600 панорама виртуал тур хэлбэрээр харах боломжтой.

Тус хэлтсийн мэргэжилтнүүд уг судалгааны болон веб сайт хийж боловсруулахад Дундговь аймгийн музей, Дундговь аймгийн Өлзийт сумын ЗДТГазар, “Урансофт” ХХК газруудтай хамтран ажиллалаа.

Чингис хаантай холбоотой зарим түүхэн газруудын виртуал тур

ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран Монголын нууц товчоонд гардаг Чингис хаантай холбоотой түүхэн газруудыг хамруулсан аялал жуулчлалын маршрут бий болгох төслийн багийнхантай хамтарч Бурхан халдун уул, Дунд жаргалант, Биндэрийн овоо, Рашаан хад, Өглөгчийн хэрэм, Дуурлиг нарс, Хэрлэнгийн хөдөө арал зэрэг газруудад панорама виртуал тур боловсруулах ажлыг эхлүүллээ. Ирэх 2013 онд сонгосон газруудад нарийвчилсан зураг авах ажил хийхээр төлөвлөж байна.

“Хүрдэт агуй”-н виртуал тур

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших эртний бичээс бүхий “Хүрдэт агуй”-н панорама виртуал турыг боловсруулж байна. Уг виртуал турыг тусламжтайгаар агуйд байх 32 бүлэг бичээсийг тодруулан харж болохоос гадна ШУА-ын Түүхийн хүрээлэнгийн судлаачдын сийрүүлэн монгол хэлэнд буулгасныг харьцуулан унших боломжтой юм. Энэхүү виртуал турыг боловсруулахад ШУА-ын Түүхийн хүрээлэн, “Урансофт” ХХК-тай хамтран ажиллаж байна.

БМСан бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт:

Тус хэлтсээс соёлын өвийн бүртгэл, баримтжуулалтын талаар зохион байгуулсан томоохон сургалт нь улсын тооллогын мэргэжил, арга зүйн сургалт байлаа. /уг сургалтын талаар өмнөх 1.1-д дурдсан болно./ Бүртгэл- мэдээллийн сангийн анхан шатны нэгж музейн бүртгэл-мэдээллийн санг мэргэжил арга зүйгээр хангаж, дараах чиглэлээр сургалт зохионы байгуулсан.

- Соёлын биет болон биет бус өвийн чиглэлээр бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, соёлын өвийг хамгаалахад музейн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангах сургалтыг 2012 оны 12 дугаар сарын 03-наас 07-ны өдрүүдэд төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган зэрэг аймгийн музейнүүд дээр биечлэн очиж зохион байгууллаа. Сургалтанд хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн П.Чинбат, Утга соёлын бв хариуцсан мэргэжилтэн Ж.Насанжаргал, сэргээн засварлагч Д.Нямдорж нар хичээл заалаа.

Сургалтанд Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймгийн музейнүүдийн бүртгэл-мэдээллийн санч, сан хөмрөгч, эрдэм шинжилгээний ажилтан, тайлбарлагч, Орхон аймгийн сумын соёлын төвийн эрхлэгч болон аймгуудын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёлын газрын соёл хариуцсан мэргэжилтэнүүд тус тус оролцлоо. /Дэлгэрэнгүй тайланг хавсаргав/

- 2012 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Монголын Үндэсний музейтэй хамтран Бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох талаар сургалт зохион байгуулав. Сургалтанд Улаанбаатар хотод 14 музейгээс Бүртгэл-мэдээллийн санч, Сан хөмрөгч оролцуулан 28 хүнийг хамруулахаар төлөвлөснөөс 27 хүн хүн оролцсон.

Энэ удаагийн сургалтын гол зорилго нь “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-тай уяалдуулан музей дэхь Бүртгэл-мэдээллийн сангийн үйл

ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр хотын музейн ажилтнуудыг арга зүйгээр хангаж, ярилцах, туршлага солилцоход чиглэгдсэн. Энэхүү зорилгынхоо хүрээнд музейд байгаа цаасан суурьтай болон цахим баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн хадгалах тухай мэргэжилтэн Ш.Энхтуяа, програмист Б.Алтансүх нар, шинэ заавар, түүний хавсралт маягтуудыг хэрхэн хөтлөх, хадгалах болон Монголын Үндэсний музей дээр Бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлж байгаа талаар Үндэсний музейн Сан хөмрөгийн бүртгэлийн албаны дарга Л.Энхтуяа, ЭША Ph.D Д.Бумаа нар заалаа. /Дэлгэрэнгүй тайланг хавсаргав/

Хамтран оролцсон сургалтуудын талаар:

2012 оны 4 ба 5 дугаар саруудад музей, соёлын өвийн чиглэлээр чиглэлээр зохион байгуулагдсан сургалтуудад хамтран оролцлоо. Үүнд:

- Хэнтий, Өмнөговь, Завхан, Төв зэрэг аймгуудын Боловсрол соёлын газар, аймгийн музейгээс зохион байгуулсан тухайн аймгуудын сумдын соёлын төвийн ажилтнуудад зориулсан сургалтууд,

- 2012 оны 5 дугаар сарын 7-ноос 10-ны хооронд зохион байгуулсан Соёлын урлагийн хороо, Дундговь аймгийн музейтэй хамтран “Олон улсын музейн ажилтны өдөр”-т зориулан зохион байгуулсан сургалт, спортын арга хэмжээ,

- Соёлын дээд сургуулаас 5 дугаар сарын 17-ноос 30-нд зохион байгуулсан соёлын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх курс зэрэг сургалтуудад оролцож “Соёлын биет өвийн бүртгэн баримтжуулалт, хадгалалт, хамгаалалт”, “Музейн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлт” зэрэг сэдвүүдээр мэргэжил, арга зүйн хичээлүүдийг хэлтсийн дарга Д.Нарантуяа, мэргэжилтэн Ш.Энхтуяа, Б.Даваацэрэн, Б.Алтансүх нар тус тус заасан.

Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар:

Тус хэлтсийн мэргэжилтэн Б.Алтансүх, Б.Даваацэрэн нар 2012 оны 11 дүгээр сарын 20-ноос 12 дугаар сарын 5-ны өдрийн хооронд Япон улсын Дошиша их сургуулийн Соёлын өвийн мэдлэг судалгааны төвд GIS болон 3D хэмжээст технологийг ашиглан түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах чиглэлээр сургалтанд хамрагдав.

Ойрын үед соёлын биет өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэх ажлыг улам бүр боловсронгуй болгох, өвийн бүртгэл баримтжуулалтад сүүлийн үеийн 3D технологийг нэвтрүүлэхээр тус хэлтсийн мэргэжилтэнгүүд шамдан ажиллаж байна.

Боловсруулсан ажлын талаар:

“Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж” төслийн явцын талаар:

Соёлын өв, түүх соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгал, утга соёлын өвийг дижитал хэлбэрээр бүртгэн баримтжуулах, музейн үзмэр, археологийн олдворын материалын бүтэц найрлагыг тодорхойлох, бэхжүүлж, хамгаалах, бүртгэн баримтжуулах орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангагдах зорилгоор 2009 онд “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж” төслийг Япон улсын Элчин сайдын яаманд өргөн барьсан. 2012 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Япон улсад айлчлах үеэр гэрээнд гарын үсэг

зурснаар төсөл хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Төслийн хүрээнд дараахи 5 төрлийн тоног төхөөрөмжийг Япон улсаас хүлээн авна. Үүнд:

1. X-Ray Analytical Microscope, 2. Portable 3D Digitizer, 3. Energy Dispersive X-ray Fluorescence (Handheld type), 4. Polarizing Microscope, 5. Fourier Transform Infrared Spectroscopy.

Тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт Япон улсын Sirius Corporation, Ogawa Seiki, Nissei Trading гэсэн 3 компани өрсөлдсөнөөс, тендерийн хамгийн бага үнэ буюу 42,500,000 (дөчин хоёр сая таван зуун мянган иен) иенд эдгээр тоног төхөөрөмжийг Монгол улсын Соёлын өвийн төвд нийлүүлэх саналаар OGAWA SEKIE компани ялалт байгуулсан. Одоогоор тоног төхөөрөмжийг нийлүүлэхтэй холбогдолтой гэрээ хэлэлцээрүүд хийгдэж дууссан ба тоног төхөөрөмжүүдийг 2013 оны 2 дугаар сарын дунд үед Монгол улс руу тээвэрлэхээр урьдчилан төлөвлөөд байна.

Гандантэгчэнлэн хийдийн улсын тооллого явуулах бэлтгэл ажлыг хангах талаар:

Соёл, спорт, аялал жуулчлалын яам /хуучнаар БСШУЯ/-наас музейн сан хөмрөгийн 2012-2013 оны улсын тооллогоор Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлэн хийдийг улсын тооллогод хамруулахаар шийдвэрлэсэн ба Соёлын өвийн төвд тус хийдийн улсын тооллогыг 2013 онд зохион байгуулан ажиллах чиглэлийг өгсөн билээ.

Тус хийдэд 1987 оноос хойш албан ёсоор улсын тооллого явагдаагүй бөгөөд Бурханы шашны холбогдолтой түүхийн ховор, нандин дурсгалууд төвлөрөн хадгалагдаж байдаг билээ.

Төрийн захиргааны төв байгууллагаас үүрэг болгосны дагуу улсын тооллогын бүртгэн баримтжуулалтын арга зүйгээр ханган, улсын тооллого явуулахад тус хийдтэй хамтарч ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тус хэлтсээс Гандантэгчэнлэн хийдэд улсын тооллого явуулахад шаардагдах төсвийн төслийг боловсруулан 2012 оны 12 дугаар сард ССАЖЯаманд хүргүүлсэн болно.

УНБМСанд цугларсан бүртгэл, мэдээллийн хадгалалт, ашиглалтын байдал, эрэлт хайлтыг боловсронгуй болгох талаар:

Тус хэлтсийн үндсэн үйл ажиллагааны нэг болох соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна. БМСанд соёлын биет болон биет бус өвийн бүртгэл, мэдээллүүд цаасан суурьтай болон цахим хэлбэрээр хадгалагдаж байдаг. Манай санд хадгалагдаж байгаа соёлын өвийн мэдээллийн хадгалалт, ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангах, тэдгээрийн эрэлт хайлтыг боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

Иймээс тус санд хадгалж буй бүртгэл, мэдээллийг товъёогжуулалтыг програм хангамжид шилжүүлэхээр төлөвлөж байна. Энэ ажлыг хийж гүйцэтгэхээр мэдээлэл, технологийн чиглэлийн Урансофт ХХК-тай 2012 оны 12 дугаар сарын 20-ноос 2013 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэл гэрээ байгуулан, програм хангамж боловсруулахаар ажиллаж байна.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

2.1. ЮНЕСКО-д илгээсэн өвүүдийн бичиг баримтын шинэчлэлт

“Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д бүртгэгдсэн “Монгол тууль”-ийг хамгаалах чиглэлээр “Монгол туулийн өвийг хамгаалж хөгжүүлэх” төсөлд СББӨ-ийн сангаас олон улсын санхүүгийн дэмжлэг авах хүсэлтийг Монголын тал 3 жилийн өмнөөс Конвенцийн хороонд өргөн барьсан бөгөөд ЮНЕСКО-гийн шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу уг төслийн баримт бичгийг удаа дараа засч боловсруулсан билээ. Конвенцийн хороо 2012 оны X сард уг асуудлыг хянан хэлэлцээд эцсийн шийдвэрийг хойшлуулаад байсан юм. 2012 оны XII.3-7-нд Парис хотноо чуулсан СББӨ-ийг хамгаалах конвенцийн Засгийн газар хоорондын VII чуулганд хорооны гишүүн орнууд болон оролцогч бусад орнууд, улс хоорондын байгууллага, ЮНЕСКО-гийн бүс нутгийн төвүүд, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн оролцоог хангасан 440 гаруй төлөөлөгч оролцлоо. Уг чуулганаар “Монгол туулийн өвийг хамгаалж хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлэхэд зориулж, 107,0 мянган ам.долларын тусламж авах монголын талын хүсэлтийг тусгайлан авч хэлэлцээд олон улсын тусламжийг Монгол улсад үзүүлэх болсон тухай шийдвэрээ 3 дахь өдрийн хуралдааны эхэнд зарласан юм. Олон улсын тусламж авахад тухайн улс орон нь тодорхой хэмжээний санхүүжилт гаргасан байх болзлын дагуу Монголын тал 78,0 мянган ам.долларын хөрөнгийг дээрх тусламжаас гадна гаргахаар төсөлд тусгагдсан болно.

Мөн тус хэлтэс нь “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалт”-д орсон “Монгол цам”, “Монгол уран бичлэг”, “Уул овоо тахих Монгол зан үйл”, СББӨ-ийн төлөөллийн бүртгэлд орсон “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийн материалд нэмэлт тайлбар, засвар хийж ЮНЕСКО-д илгээв.

2.2. “Ардын урлагийн их наадамд шалгарсан авъяастнуудын урын сан, гар урлалын бүтээл” эмхэтгэл хэвлүүлэх

Увс, Завхан, Дундговь, Өвөрхангай, Орхон, Дорнод, Төв аймаг болон Багануур, Хан-Уул дүүргүүдэд бүсчилэн зохиогдсон АУИН-ын II шатны оролцогч нийт авъяастнууд, Улаанбаатар хотод зохиогдсон III шатны шалгаруулалтад оролцогчдын урын сан, аман өвөөр эмхэтгэл хэвлүүлэн гаргав. Уг номонд АУИН-д оролцогчдын аман өвийг буулгаснаас гадна ардын дууны ая эгшгийг нь нотлосон бөгөөд энэ ажилд шүүгчдийн бүрэлдэхүүнд орсон Монгол улсын Урлагийн Гавъяат зүтгэлтэн П.Хаянхирваа оролцсон юм. Мөн энэхүү номын хавсралт болгон “Ардын урлагийн их наадам” баримтат кино DVD-г бүтээв. Цаашид дөрвөн жил тутамд зохиогддог АУИН-ын материалыг эмхэтгэл болгон хэвлүүлж байх уламжлал тогтоож, хэвлүүлэх зардлыг төсөвт тусгаж байх саналтай байна.

2.3. Урианхай цуурын уламжлал өвийг хойч үедээ өвлүүлэх хамгаалах сургалт

“Хүннү цуурчдын холбоо”-ны тэргүүн Б.Наранбаттай гэрээ хийж, 2012.III.10-2012.IV.10-ны хооронд Орхон аймагт цуурын сургалт зохион байгуулав. Орхон аймгийн “Наран” цогцолбор сургуулийг түшиглэн хийсэн цуурын анхан шатны эл сургалтанд 2 эмэгтэй, 11 эрэгтэй нийт 13 хүн хамрагдав. Энэхүү сургалтанд хамрагдсан цуурчдаас Х.Пүрэвсүрэн, С.Сарангэрэл, Б.Төрболд, Н.Батхишиг нар Орхон аймагт 2012.III.29-30-ны хооронд зохиогдсон Урианхайн Соёл урлаг, спортын “Алтан хүрээ” VII их наадамд амжилттай оролцсон болно.

Цуурын сургалтыг баклаврын боловсрол олгох сургалтад сонгон суралцах хэлбэрээр оруулж хөтөлбөр, стандартыг боловсруулах, “Ардын барил” хичээлд ашиглах хэрэглэгдэхүүнийг Соёлын өвийн төвийн сан хөмрөгөөс авч ашиглах асуудлаар 2012.XI.5-нд Соёлын өвийн төв, Хөгжим бүжгийн коллежийн хооронд хамтран ажиллах “Санамж бичиг”-т гарын үсэг зурав.

СУИС-ийн Хөөмэйн ангийн оюутнуудад “Тууль”, “Цуур”-ын тухай лекц уншиж, сонгон суралцах хэлбэрээр сургалт явуулахад нь тусламж болгож, “Цуурын эгшиг” DVD, Монгол Туульчдын урын сангийн DVD бичлэг хэрэглэгдэхүүнийг гардуулав.

2.4. “Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга-битүү амьсгаа” – ны урлагийг судлах сурталчлах

“Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга-битүү амьсгаа”-ны урлагийг Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн ЮНЕСКО-гийн жагсаалтанд бүртгэсэн батламж гардуулах ёслолын ажиллагаа 2012.VI.11-нд болов. Энэхүү ёслолын ажиллагааны хүрээнд лимбэчдийн тоглолт, фото зургийн үзэсгэлэн зохион байгуулж, амжилт гаргасан Л.Алтансүх, Н.Жамбалжамц, Г.Нямжанцан нарыг МУСТА цол тэмдгээр, МУГЖ Ө.Батжаргал, МУГЖ Д.Галсантогтох нарыг СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастны улсын жагсаалтанд бүртгэгдсэн батламж олгон, олон нийтэд сурталчлав.



Батламжийн хуулбарыг Алдарт гавъяат хагжимчин, лимбэч Л.Цэрэндорж агсны нэрэмжит Хөгжим бүжгийн коллежийн лимбэний ангид болон СУИС-ийн эрдмийн өргөөнд залах ёслолыг зохион байгуулав.

2.5. Соёлын биет бус өвийн сурталчилгааны хэвлэмэл болон дижитал ном, гарын авлага хэвлүүлэх

Соёлын өвийн төв, тус төвийн Ховд аймаг дахь орон тооны бус салбарын “Төгөлдөр” студи хамтран Говь-Алтай аймгийн Бугат сумын уртын дууч Б.Төрмөнхийн дуулсан Баруун халхын мартагдаж байгаа 20 уртын дуу, МУГЖ Б.Дариймаагийн дуулсан Дархад ардын дуунууд, Төв халхын уртын дуучин, МУГЖ С.Сумъяагийн дуулсан Төв Халхын уртын дууны аудио CD-ийн эхийг бэлтгэж хэвлэн гаргав.

2.6. Уртын дууг хойч үед өвлүүлэх сургалтын бэлтгэл ажлыг хангах

Уг ажил Улаанбаатар хот болон Өвөрхангай аймгийн хэмжээнд хийгдсэн. Цаашид бусад аймгуудтай ярилцаж тохиролцох, биечлэн судлах, томилолтоор ажиллах зайлшгүй шаардлагатай байна. Энэ чиглэлээр Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд V. 4-6-нд болсон “Бурхдын шуранхайтай нутаг” уртын дууны бэсрэг наадмыг зохион байгуулахад оролцов.



2.7. СББӨ-ийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх

2012 оны СББӨ-ийн шинэчилсэн бүртгэл гарсантай холбогдуулан “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” соёлын ажилтнуудад зориулсан гарын авлагыг шинэчлэн хэвлүүлэв. 2010 оноос СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдын бүртгэл, тооллогыг улсын хэмжээнд явуулж эхэлсэн бөгөөд 2012 оны шинэчилсэн бүртгэлд 6925 өвлөгч бүртгэгдсэн байна. Энэ нь 2011 оны байдалтай харьцуулахад 1435 өвлөн уламжлагч нэмж бүртгэгджээ.

Сүүлийн 3 жилд ирүүлсэн судалгааны дүнг харахад аймаг орон нутагт, ялангуяа сумдад уг ажлын зорилго, ач холбогдлыг дутуу ойлгож, урьд өмнө гаргасан алаг цоог мэдээ, судалгааг он сарыг нь өөрчлөх төдийгөөр аргацаан илгээх, СББӨ-ийн анхан шатны бүртгэл мэдээллийг бүрдүүлэх ажлыг цалгардуулах дутагдал түгээмэл ажиглагдаж байна. Соёлын биет бус өв, түүнийг өвлөн тээгчийг тогтоох энэ хариуцлагатай ажилд аймаг, сумд харилцан адилгүй хандаж буйг дараах судалгаа харуулж байна. Тухайлбал: СББӨ-ийг өвлөн уламжлагчид, мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийг бүртгэсэн (төгөлдөр хуурч, зохиолын дуучин, тайзны зураач, гэх мэт) мөн 2011 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалтыг давхардуулан илгээх, уламжлагчийн мэдээллийг хагас дутуу бөглөх зэрэг нийтлэг дутагдалтай байгаа нь

улсаас гаргасан хууль тогтоомж, мэдээлэл дутмаг, салбар зөвлөл, арга зүйч, бүртгэлийн ажилтны ажил хэргийн уялдаа муу байгаа зэрэг СББӨ-ийн анхан шатны бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цалгардуулж байгаа түгээмэл дутагдал ажиглагдаж байна.

Иймд СББӨ-ийн өвлөн уламжлагчийн бүртгэл-мэдээллийн санг баяжуулах, шавь болон танхимийн сургалт явуулах, бүртгэлийн шалгуурыг нарийвчлан гаргах, тоог бус авъяас чадварыг чухалчлах, бүртгэл, судалгааны мэргэшсэн багтай болох /салбар зөвлөл/, техник, төхөөрөмжөөр хангах зэрэг бүртгэлтэй холбоотой тулгамдсан асуудлууд тавигдаж байна.


Хүснэгт 1

**Орон нутгийн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн
бүртгэлийн дүн**

№	Аймгийн нэр	Нийт сумд	2010 оны	2011 оны	2012 оны	Нийт өвлөгчид
			бүртгэлд хамрагдсан өвлөгчдийн тоо			
1	Архангай	19	99	5	19	125
2	Баян-Өлгий	13	30	152	4	186
3	Баянхонгор	20	183	60	4	247
4	Булган	16	89	0	48	137
5	Говь-Алтай	18	167	116	20	303
6	Говьсүмбэр	3	32	34	24	90
7	Дархан-Уул	4	12	6	4	22
8	Дорноговь	14	93	2	146	241
9	Дорнод	14	125	6	27	158
10	Дундговь	15	163	72	0	235
11	Завхан	24	373	97	43	513
12	Орхон	2	18	2	52	72
13	Өвөрхангай	19	76	83	46	205
14	Өмнөговь	15	101	63	19	183
15	Сүхбаатар	13	53	60	8	121
16	Сэлэнгэ	17	173	241	52	466
17	Төв	27	221	64	157	442
18	Увс	19	207	5	19	231
19	Ховд	17	213	2	1	216
20	Хөвсгөл	23	234	207	483	924
21	Хэнтий	18	214	0	259	473
	Нийт	330	2876	1277	1435	5588

2010-2012 оны өвлөн уламжлагчдын нэгдсэн дүн

№	Засаг захиргааны нэгж		2010 оны	2011 оны	2012 оны	Нийт өвлөгчийн тоо
			бүртгэлд хамрагдсан өвлөгчдийн тоо			
1	21 Аймаг	333 сум	2876	1277	1435	5588
2	9 дүүрэг	128 хороо	651	686		1337
			3527	1963	1435	6925



СББӨ-ийн төрөл зүйлийн ангилал



СӨТ-ийн БМС дахь СББӨ-ийн дуу, дүрс бичлэгийн архивын материал, хальснуудыг дугаарлаж, товъёогжуулав. ББӨХ-ийн холбогдох бичиг баримтуудыг цэгцлэж, хаягжуулав.

Мөн Говь-Алтай аймгийн Бугат сумын уртын дууч Б.Төрмөнхийн 7 цагийн аудио видео бичлэг, Говь-Алтай аймгийн Бугат сумын өвлөн уламжлагчдын 4 цагийн аудио видео бичлэг, Морин хуурын олон улсын III наадмын /V сарын 1-2/ 4 цагийн, “Монгол туульчдын урын сангийн улсын үзлэг”-ийн 40 гаруй цагийн видео материалыг СӨТ-ийн архивын сан хөмрөгт авлаа.

Нийтдээ 2012 онд уртын дуу, морин хуур, тууль, лимбэ, уран хатгамал зэрэг СББӨ-ийн 80 орчим цагийн видео материал, 10 гаруй цагийн аудио материалаар СӨТ-ийн сан хөмрөгийг баяжууллаа.

2.8. Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй хийгдсэн ажлууд

2.8.1. Сургалт семинар

Японы Итгэлцлийн сангийн ивээлээр ССАЖЯ, түүний харъяа СӨТ, ЮНЕСКО-той хамтран хэрэгжүүлж буй “СББӨ-ийг хамгаалах тухай конвенцийг хэрэгжүүлэхэд Монгол улсын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн зөвлөлдөх уулзалтыг V сарын 28-29-нд зохион байгууллаа. Энэхүү төсөл нь 2012-2013 онд 3 үе шаттай хэрэгжих томоохон төсөл бөгөөд эхний сургалт семинарийг 2012.XI.19-23-нд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Сургалтыг Токио дахь Бодлого судлалын Үндэсний хүрээлэнгийн Урилгын

профессор Норико Айкава, Сингапур улс дахь Милоу студийн Өвийн төсөл ба харилцаа холбооны хэлтсийн дарга Сюзанн Ог нар удирдан явууллаа. Тус сургалтанд ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн Газрын Соёлын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Биатрис Калдун, ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн Газрын Соёлын төсөл хариуцсан мэргэжилтэн Жулиен Гленат, олон улсын ажиглагчаар ЮНЕСКО-гийн Ази-Номхон далайн бүсийн СББӨ-ийн олон улсын сургалтын төв /CRINAP/-ийн судлаач Гэ Ючинг, туслах судлаач Шу Мингжи, Монголын эрдэмтэн судлаачид, төрийн болон ТББ-ын төлөөлөгчид, өвлөн уламжлагчид нарын 40 гаруй хүн оролцсон том сургалт боллоо.

Энэхүү сургалт семинарт зориулж ЮНЕСКО, Япон улсын итгэлцлийн сангийн дэмжлэгээр “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн үндсэн баримт бичгүүд”, “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийг хэрэгжүүлэхэд Монгол улсын чадавхийг бэхжүүлэх нь” сургалтанд зориулсан гарын авлага, номыг хэвлэн гаргалаа.





2.8.2. СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастнуудад батламж гардуулах ёслол

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2003 оны 432-р тушаал, 2010 оны 546-р тушаалын хавсралтаар батлагдсан СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастнуудад батламж гардуулах ёслолын ажиллагааг 2012.V.28-нд зохион байгуулав. Уг ёслолд Улаанбаатар хотод оршин суугаа 30 гаруй өвлөн уламжлагчид хамрагдлаа. Энэ үеэр СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авъяастнуудад олгодог мөнгөн шагналыг мөн олгосон бөгөөд энэхүү жагсаалтанд орсон хэдөө орон нутагт оршин суугаа билиг авъяастнуудад шагналыг дансаар шилжүүлсэн болно.



2.8.3 СББӨ-ийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйн сургалт, дадлага

Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах, соёлын ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор тус хэлтсийн ажилтнууд Хөвсгөл /III сарын 11-12/, Хэнтий /III сарын 11-12/, Булган /V сарын 11-13/, Завхан /V сарын 4/, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон /XII.3-9/ аймгийн сумдын соёлын төвийн эрхлэгч, бүртгэл мэдээллийн сангийн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгч, сургалт дадлагыг зохион байгуулав.

2.8.4 СББӨ-ийн сурталчилгаа, мэдээлэл

Ардын урлагийн их наадамд шалгарсан авъяастнуудын урын сан, гар урлалын бүтээлээр баримтат кино бүтээв.

“Монгол цуур” DVD, цомгийг хэвлэн гаргаж, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн Соёлын ажилтнуудад хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

СӨТ-өөс эрхлэн гаргадаг Соёлын өв № 5 сэтгүүлийг бэлтгэж хэвлүүлэх ажлыг тус хэлтэс хариуцан гүйцэтгэв. Мөн Соёлын өв №6 сэтгүүлд зориулан СББӨ-тэй холбогдолтой 9 материалыг бэлтгэн хэвлүүлэв.

СӨТ-ийн тухай богино хэмжээний кино- видео танилцуулга хийлээ.

Уртын дуучин М.Дорждагвын гаргасан “Монгол төрийн уртын дуу” цомгийн /төрийн 9 уртын дууг бүрэн эхээр нь дуулсан/ хавсралтыг монгол бичгээр буулгахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

2.8.5 СББӨ-ийн наадам

2012.VII. 8-9 нд Ховд аймагт болсон “Олон улсын хөөмэйн II наадам”-ын бичлэгийг хийж, СӨТ-ийн бүртгэл мэдээллийн санд авлаа. Мөн Ховд аймгийн “Төгөлдөр” студитэй хамтран хөөмэйн наадмын тухай баримтат кино бүтээлээ.



ЮНЕСКО-гийн “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”-д бүртгэгдсэн “Монгол тууль”-ийг хадгалж хамгаалах, туульчдын урын санг өргөжүүлэх, залгамж холбоог бэлтгэх, ур чадварыг нь бодитой үнэлж зэрэг дэв олгох, алдаршуулах зорилгоор “Монгол туульчдын урын сан” улсын үзлэгийг 2012.X.11-X.13-ны хооронд зохион байгууллаа. Үзлэгт нийслэл Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Увс, Ховд, Дорноговь аймгаас шалгарсан 17 туульч оролцож, “Хүрэл гэрэгэ”-г Э.Баатаржав, “Мөнгөн гэрэгэ”-г Н.Анхбаяр, “Алтан гэрэгэ”-г А.Балдандорж нар хүртлээ. Энэхүү арга

хэмжээ нь цаашид 2 жил тутамд зохион байгуулагдаж байх юм. Тус үзлэгийн 40 гаруй цагийн видео материалыг БМС-д авч архивлав.



2.8.6 ЮНЕСКО-д явуулах Монгол улсын хугацаат тайлан

Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн ЮНЕСКО-гийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол тууль”, “Монгол цуур”, “Монгол бүжгийн уламжлалт урлаг-Бий биелгээ”-ний өнөөгийн төлөв байдлын тухай (4 жил тутамд явуулдаг) үндэсний тайланг боловсруулах ажлыг тус хэлтэс хариуцан гүйцэтгэв.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-III. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Улс, аймгийн 14 музейн 81 ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах:

2012 онд Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс нь улс, аймгийн 14 музейн 81 үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлахаар төлөвлөн ажилласан.

№	Байгууллага	Нийт сэргээн засварлах үзэмрийн тоо	Хүлээж авсан үзэмрийн тоо	Сэргээн засварлагдаж байгаа үзэмрийн тоо	Сэргээн засварлагдсан үзэмрийн тоо	Засварт ороогүй үзэмэр
1	Богд хааны ордон музей	3	3	1		2
2	Уран зургийн галерей	11	9	3	6	
3	Монголын үндэсний музей	9	Үзмэр хүлээж аваагүй			
4	Археологийн хүрээлэн	3	Үзмэр хүлээж аваагүй			
5	Сэлэнгэ аймгийн музей	2	2		2	
6	Сүхбаатар аймгийн музей	5	5		5	
7	Дундговь аймгийн музей	10	10	5	4	1
8	Булган аймгийн музей	1	1		1	
9	Хөвсгөл аймгийн музей	4	4		3	1
10	Завхан аймгийн музей	4	3	1	2	
11	Баянхонгор аймгийн музей	5	5		5	
12	Говь-Алтай аймгийн музей	3	3	1		2
13	Төрийн түүхийн музей	4	4		4	
14	Эрдэнэ зуу музей	15	2012.12 дугаар сард хүлээж авсан			
15	ШУТИС-ийн нийгмийн технологийн сургууль	2	2	1	1	
	Нийт	81	51	12	33	6

2012 онд нэмэлт захиалгаар сэргээн засварласан музейн үзэмрүүд

№	Байгууллага	Металл	Шавар	Мод	Даавуу	Тайлбар
1	Хар хорум музей	160 орчим	21	24	30 орчим	Баяннуурын шороон бумбагарын бунхант булшнаас гарсан археологийн олдвор алт мөнгөн зоос, алт мөнгө хүрэл эдлэл, шавар баримал, модон эдлэл, даавууны тасархай хэсгүүд
2	МУИС-Археологийн олдвор				12	эсгий ширдэг 1ш, дээл 3ш, хормогч 1ш, малгай 1ш, аяганы уут 1ш, дээлийн тасархай хэсгүүд 5ш.
3	Эрдэнэзуу музей			1		зандан зуу сүм сийлбэр
4	Дорнод аймгийн музей			1	10	5 хос гутал, дэвүүр
5	Увс аймгийн музей	1			2	шүрэн гутал 1ш, малгай 1ш, мөнгөн суврага 1ш,
6	Монголын үндэсний музей	7				Төмөр дөрөө 1ш, алх 1ш, мөнгөн бугуйвч 2ш хүрэл толь 1ш, алт шармал чимэглэл 2ш

Сэргээн засварлах ажил хийгдэж байгаа үзмэрүүдээс:

1. Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хэрмийн шороон бумбагар хэмээх газарт орших VI-VII зууны үед холбогдох түргийн үеийн бунхант оршуулагын байгууламжаас гарсан археологийн олдворуудын 80 орчим хувийг сэргээн засварлаж дууссан.

Нэмэлт захиалгаар гүйцэтгэсэн томоохон ажлууд болон үл хөдлөх дурсгалууд:

2. Улаан хэрмийн бунханы ханын зургийг хамгаалах судалгааны ажлын хүрээнд Итали улсын сэргээн засварлагчын хамт газар дээр нь ажиллаж өнөөгийн хадгалалтын орчин, нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид дурсгалыг хэрхэн хамгаалах талаар судалгаа хийх, 2012 оны 11 дүгээр сарын 10-наас 20-ний хооронд ханын зургийн гадаргуйд үүссэн бохирдолыг цэвэрлэх, хучилтыг дахин шинээр хийх ажлыг хийж гүйцэтгэв.
3. Эрдэнэ зуу музейн баруун зуугийн ханын зураг, баганы луу, гол зуугийн бурхадын сэнтий гарын барьц, үсний чимэглэлийн эвдрэл гэмтлийг сэргээн засварлах ажлыг

2012 оны 6 дугаар сарын 6-наас 19-ний хооронд сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

3.2 Монголын Уран зургийн галерейн 50 ширхэг уран зургийг утаа тортогний бохирдлоос цэвэрлэх:

2008 оны 7 дугаар сарын 1-ны үйл явдал, 2009 оны 5 дугаар сарын 18-нд тус музейн сан хөмрөгт гарсан галнаас утаа тортогт бохирдож, усанд норж гэмтсэн 900 гаруй зургаас энэ жил 50 ширхэг зураг цэвэрлэхээр төлөвлөсний дагуу 25 ширхэг зургийг цэвэрлэсэн.

3.3 Уран зургийн галерейн шатсан уран зургаас 18 ширхэг зургийг сэргээн засварлах:

2008 оны 7 дугаар сарын 1-ны үйл явдал, 2009 оны 5 дугаар сарын 18-нд тус музейн сан хөмрөгт гарсан галнаас утаа тортогт бохирдож, усанд норж гэмтсэн зургийг сэргээн засварлах ажлыг хүрээнд 2012 онд 18 ширхэг зураг сэргээн засварлахаар төлөвлөж, сэргээн засварлах ажилд шаардлагатай материал, тоног төхөөрөмжийг 2012 оны 5 дугаар сард суурилуулснаар сэргээн засварлах ажил эхлэж 14 ширхэг зураг засварлаад байна.

3.4 Их бурхант дурсгалын 1 дүгээр үе шатны сэргээн засварлах ажил

Их бурхант дурсгалыг сэргээн засварлах ажилд шаардлагатай археологийн судалгааг 2012 оны 6 дугаар сарын 08-наас 27-ны хооронд археологийн хүрээлэнтэй хамтарч хийв. Дурсгалын цементэн бохирдлыг цэвэрлэх, гол шүтээн бурханы хоёр талын хэрмэн хананы өрлөгийг задлан өрөх, гол шүтээн бурханы нүүрний хэсгийг сэргээн засварлах, 2012-2013 онд хэрэглэгдэх чулуу олборлох, Буйр нуурын дэргэдэх 5 Аюуш бурханг сэргээн засварлах ажлыг 2012 оны 7 дугаар сарын 17-ноос 2012 оны 10 дугаар сарын 19-ний хооронд хийж гүйцэтгэв.

3.5 Аялал жуулчлалын бүсэд хамрагдсан 3 ширхэг газар танилцуулга самбар хийлгүүлэх:

2012 онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өвөр, Хядаг, Улаанбаатар хот Ван хааны ордоны туурь зэрэг 3 газарт танилцуулга самбар байрлуулахаар төлөвлөсний дагуу уг танилцуулга самбаруудыг 2012 оны 3 дугаар улиралд захиалгаар хийлгэсэн. Тэдгээр самбаруудыг тээвэрлэн хүргэж, байрлуулах ажлыг энэ оны 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн ба Улаанбаатар хотын дэргэдэх Ван ханы ордны туйр нь судалгаа шинжилгээний хувьд нэгдсэн ойлголтонд хүрээгүй, маргаантай байгаа тул дээрх самбарын оронд Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт орших Чингис хаантай холбоотой Сэрвэн хаалганы дурсгалындэргэд танилцуулга самбарыг хийж байршуулав. Уушигийн өвөрт тавигдах самбарыг 10 дугаар сард Хөвсгөл аймагт цас ихээр орсон тул байрлуулах ажил хойшлогдож 2013 оны 2 дугаар улиралд хийхээр төлөвлөж түр хугацаагаар хойшлуулав.

3.6 Төв аймгийн Дэлгэрхаан сум Кулчурын дурсгалыг бэхжүүлэх, Дорноговь аймгийн Цувираагийн хийдийн ханын зургийн тандалт судалгаа

2012 онд Төв аймгийн Дэлгэрхаан сум Кулчурын дурсгалыг хамгаалах ажлын хүрээнд цэвэрлэж бэхжүүлэх, хагархай хэсгүүдийг эвлүүлж, сэргээн засварлах, Дорноговь аймгийн Цувираагийн хийдийн хананд ханын зураг байгаа эсэхийг нягтлаж тогтоох тандалт судалгааны ажлыг 2012 оны 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөн ажилласан боловч сэргээн засварлах ажилд хэрэглэх материал, цаг агаарын тодорхой хэмийн дулаан шаарддаг, Их бурхант дурсгалын ажилд анхаарал хандуулах шаардлага тул 2012 онд энэ ажлыг хийх боломжгүй болсон.

Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх талаар:

- Соёлын өвийг судлах хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх ажлын хүрээнд 2012 оны 5 дугаар сарын 1-нээс 11-ний хооронд Герман улсын Гёте-Институт, ЮНЕСКО, Гандантэгчэнлэн хийдтэй хамтарсан “Сүм хийдүүдийн цаасан баримтыг хадгалан хамгаалж сэргээн засварлах нь” сургалт семинарт Гандантэгчэнлэн хийдийн номын сан дээр түшиглэн зохион байгуулсан сургалтанд тус төвийн сэргээн засварлагч О.Оюунчимэг, А.Мөнгөнцоож, Б.Мягмарсүрэн нар оролцсон.
- АНУ-ын Вильмастоуны хотын уран зураг сэргээн засварлах төв, Атланта хотын урэн зураг сэргээн засварлах төвийн сэргээн засварлагчдыг урьж уран зургийн сэргээн засварлах зориулалтын халдаг ширээг хэрхэн ашиглаж сэргээн засварлалт хийх дадлага сургалтыг 2012 оны 5 дугаар сарын 12-ноос 17-ны хооронд өөрийн төв дээр зохион байгуулав.
- Улаан хэрмийн Шороон бумбагарын бунханы ханын зургийг хамгаалах судалгааны ажлын хүрээнд Итали улсын сэргээн засварлагч Лужан Лансфорд Родолфо булш бунханы ханын зургийн хадгалалт хамгаалалт сэдэвтэй сургалтанд сэргээн засварлагчыг хамруулав.
- Монголын үндэсний музей, Франц улсын Парис хотын Угсаатны үндэсний музейтэй хамтарсан “Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт” сэдвийн дор Монголын үндэсний музей дээр 2012 оны 6 дугаар сарын 15-наас 17-ны хооронд зохион байгуулсан сургалтанд тус төвийн сэргээн засварлагч О.Оюунчимэг, Б.Мягмарсүрэн нар оролцов.

Боловсруулсан бусад ажлын талаар:

Төвийн орон тоог нэмэгдүүлэх саналын тухайд:

Соёлын өвийн төвийн үйл ажиллагааны далайц, өнөөгийн нөхцөлд хийж гүйцэтгэж байгаа ажлын ачаалал, тус төвийн шинээр баригдах барилга зэргээс хамаарч төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Иймээс тус

төвөөс зайлшгүй нэмэгдүүлэх орон тооныг саналыг боловсруулан, 2012 оны 6 дугаар сард холбогдох дээд байгууллагуудад хүргүүлсэн.

Цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт:

Сэргээн засварлах үйл ажиллагаанд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжөөр дэс дараалалтай хангах асуудлыг онцгой анхаарч үзэж жил тутамд байгууллагын төсөвт сэргээн засварлах тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан төсвийг тогтмол төсөвлөж өгөх.

Сэргээн засварлах ажилд байнга ашигладаг зарим нэр төрлийн хэрэгцээт химийн бодис, материалууд нь дотоодын зах зээлд байдаггүй, гадаад зах зээлээс худалдан авахад өнөөгийн төсөв нь туйлын бага тул сэргээн засварлах ажлын материал худалдан авах төсвийг нэмэгдүүлэх.

Гадаад зах зээлээс хэрэгцээт химийн бодис, тоног төхөөрөмж материалууд худалдан авах үед химийн бодис импортлогч хувийн компануудад ханддаг хэдий ч зах зээлийн үнээс хэтэрхий өндөр үнэ санал болгох, тухайн бодисыг нийлүүлэх боломжгүй тул худалдан авахад бэрхшээл учирдаг. Тиймээс соёлын өвийн төв нь өөрийн хэрэгцээт сэргээн засварлах ажилд шаардлагатай химийн бодис материалыг импортоор оруулж ирэх эрхтэй болох шаардлагатай байна.

Соёлын өвийн төв нь Монгол улсын хэмжээнд байгаа соёлын өвийн бүхий л төрөл зүйлийг бүртгэн баримтжуулах, мэдэллийн сан бүрдүүлэх, хамгаалах, сэргээн засварлах, өвлөн уламжлуулах, соёлын өвийг хамгалах чиглэлээр ажиллаж буй ажилтнуудыг арга зүйгээр хангах зэргээр үндэсний хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа нь бусад музей, соёлын байгууллагаас ажлын ачааллын хувьд асар их, соёлын өвийг хамгаалах цар хүрээ, үйл ажиллагаа нь өргөн байна. Иймд тус төвийг үндэсний хэмжээний байгууллага болгох, төвийн мэргэжилтэн ажилтнуудыг цалингийн сүлжээ зэрэглэлийг 1-2 төвшингийн дээр тогтоох шаардлага байна гэж үзэж байна. Иймд цалингийн шатлалыг дээшлүүлэх асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд уламжилж өгөхийг хүсэж байна.

Тайлан бичсэн.

Соёлын өвийн төвийн захирал

Г.Энхбат

2012 оны 12 дугаар сар

---o0o---